



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/28)

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Эмнэлэгийн тусламж үйлчилгээний авто машин (Хөвсгөл) ЭМЯ/20240102054 дугаартай Багийн эмчийн мотоцикл шаардлагатай сумдыг хангах, Мотоциклийн шаардлагатай запас, сэлбэг багаж Багц 2-г нийлүүлэхээр 29,650.000 (Хорин есөн сая зургаан зуун тавин мянга) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Хөвсгөл Цонх” ХХК -ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Хөвсгөл Цонх” ХХК -тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

О.Дагиймаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл
мэндийн бодлого хариуцсан

мэргэжилтэн)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан

Ахлах мэргэжилтэн)

Б.Бадамгарав (“Хөвсгөл Цонх” ХХК-ийн захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ё.Ариунзаяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө
оруулалтын хэлтсийн Авто тээврийн


улсын байцаагч)

671 3010877 d/A4

3. Эмнэлэгийн тусламж үйлчилгээний авто машин (Хөвсгөл) Багийн эмчийн мотоцикл шаардлагатай сумдыг хангах, мотоциклийн шаардлагатай запас, сэлбэг багаж нийлүүлэх гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогчийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ